



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/607

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.1, 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хавсралтад заасан нийт 107,228,325.00 (нэг зуун долоон сая хоёр зуун хорин найман мянга гурван зуун хорин тав) төгрөгийн үнэ бүхий, үлдэх өртөггүй тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургууль (Б.Болор), Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т зөвшөөрсүгэй.

2.Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Налайх дүүргийн Засаг даргын тамгын газар (Ж.Алтангэрэл), Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110202951



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
 05 дугаар сарын 28 өдрийн
 1607 дугаар захирамжийн
 хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Өмч эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх байгууллага
1	Туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл	Тоёото ланд крузер J100	00-30 УБ0	JТЕНТ05J45 2068286	2005 2008	1	75,845,900.00	75,845,900.00	-	Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургууль	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
2	Суудлын тээврийн хэрэгсэл	Хьюндай Элентра	08-12 УНУ	КМНДG41C BDU687812	2012 2013	1	31,382,425.00	31,382,425.00	-	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	Налайх дүүргийн Засаг даргын тамгын газар
Нийт дүн							107,228,325.00	107,228,325.00			